

Өлгий сумын ЗДТГ-ын 7 хоногт хийсэн ажлын мэдээлэл

- Байгууллага, ААН-үүдээр явж хотын соёлжилт тохижилтын талаар байгууллагуудад зөвлөгөө өгч мэдэгдэх хуудас тарааж гарын үсэг зуруулан ажиллав.
- Улаанбаатар хотод болох “Мишээл Экспо” үзэсгэлэн худалдаанд ЖДҮ-лэл эрхлэгч нараас 6 иргэн, аж ахуйн нэгжийг оролцуулахаар аймгийн ХОХБодлогын хэлтэст судалгааг хүргүүлэв.
- 3,9,12,13-р багуудын алслагдсан хэсэгт суурьшсан айл өрхийн худгийн хэрэгцээний судалгааг гаргав.
- 13-р багт байгаа гүний худгийн ашиглалтыг шалгаж цаашид хариуцан ажиллах иргэнтэй гэрээ байгуулах асуудлыг шийдвэрлэв.
- Улсын тэмдэгтийн хураамж төлсөн хүнсний дэлгүүрүүдэд тамхи худалдах тусгай зөвшөөрлийг олгосон болно.
- Төв цэнгэлдэх хүрээлэнд, авто замын тэмдэг тэмдэглэгээний шинэчилэл засварын ажлын төсвийг гаргуулан бэлэн болгов.
- Бүх ажилтан албан хаагч, БЗДарга, БИНХДарга, БНБ нартай “Хуулиа” дээдлье хууль эрх зүйн сургалтанд хамруулсан.
- ЗД, ЗДТГ-ын дарга, ЗААлбаны ажилтанууд Баруун бүсийн хувийн хэвшлийг дэмжих нь” сургалтанд хамрагдсан.
- Хогны хураамжыг шинэчилэн тогтоож мөрдөж ажиллах албан даалгавар өглөө.
- Ногоон байгууламж болон цэцгийн мандлуудыг услаж мод цэцэг тарих үйл ажиллагаа явагдаж байна.
- Өлгий сумын мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх дунд хугацааны стратегийг 2017-2020 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргав.
- УБ хотод болох малчдын зөвлөгөөнд оролцох Хотгор 7-р багийн малчдын анкет, жагсаалтыг маягтын дагуу гарган өгч зөвлөгөөнд оролцуулах арга хэмжээ авав.
- МАА, Газар тариалангийн холбогдолтой мэдээ, судалгаануудыг ХХААГ-т хүргүүлэв.
- Сум хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл авсан, хугацаа хэтэрсэн муу зээлүүдийг холбогдох хуулийн байгууллагад шилжүүлэн эргэн төлүүлэх бэлтгэл ажлыг хангав.
- 8,13-р багийн иргэдээс газрын маргааны талаар гомдол ирсэн, гомдлын дагуу газар дээр нь очиж зохих мэргэжилтэнүүдээ явуулж шийдвэрлэсэн.
- Гудамж зам талбайн цэвэрлэгээ хийж 4 тн хог ачиж хогийн цэгт хүргэв.
- 4-р багийн машин мөргөж гэмтээсэн шугамыг засварлаж ашиглалтанд оруулав.

Өлгий сумын ЗДТГ